

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр: Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хороо	Нэгжийн нэр: Спортын хэлтэс
Албан тушаалын нэр: Спортын хэлтсийн дарга	Албан тушаалын ангилал, зэрэглэл: ТҮСБ-5
Ажлын цаг: Ажлын өдөр 8 цаг	Ажлын байрны албан ёсны байршил: Багануур дүүргийн 5-р хороо, Залуус хэсэг /12100/ Залуусын гудамж 6 тоот
Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн	Онцгой нөхцөл: Хамаарахгүй
<b>II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ</b>	
Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах, тамирчдын залгамж халааг бэлтгэх чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг хорооны даргын өмнө хариуцна.	
Албан тушаалын зорилт:	
1. Биеийн тамир, спортын тухай хууль, төрөөс баримтлах бодлого, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцох, тайлагнах;	
2. Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг уялдуулах, тамирчдын залгамж халааг бэлтгэх, спортын үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх, хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах;	
3. Спортын үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	
4. Бусад хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;	
	Гүйцэтгэл шалгуур үзүүлэлт
	Хариуцлага оролцооны хэлбэр (Шийдвэрлэх Ш, Гүйцэтгэх-

Зорилт	Албан тушаалын чиг үүрэг		Г,Хянах-Х,Туслах-Т)
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Биеийн тамир, спортын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2.Засгийн газрын болон Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилтод тусгагдсан хамаарах заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэл, үр дүнг тооцох, тайлагнах;	Үр дүнг тооцож тайлагнасан байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Дүүргийн хэмжээнд зохион байгуулах спортын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах;	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн хувь, үр дүнг үнэлж дүгнэсэн байна.	Г, Х, Ш
	2.Дүүргийн хэмжээнд үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, сургалт дасгалжуулалт, тамирчдын амжилтыг дээшлүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулах, шинэчлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах;	Эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгосон байна.	Г, Х
	3.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, спортын мэргэжлийн холбоо, клубүүдийн хамтын ажиллагаа, харилцан туршлага судлах ажлыг өргөжүүлж, тэдгээрийн ажлын үр дүнг дээшлүүлэх, үнэлж дүгнэх, урамшуулах ажлыг зохион байгуулах;	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	Г, Х, Ш
	4.Спортыг хөгжүүлэх орчин нөхцөл, барилга байгууламж, материаллаг бааз, хүний нөөц, үйл ажиллагаа, ажил үйлчилгээ,	Мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	Г, Х

	арга хэмжээтэй холбоотой судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, сурталчлах;		
	5.Олон улсын чанартай спортын уралдаан тэмцээн төлөвлөх, дүүрэгт зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;	Дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Г
	6.Биеийн тамир, спортын байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлж, харилцан баг тамирчид, мэргэжилтнүүдээ солилцох, туршлага судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;	Хамтын ажиллагаа сайжирсан байна.	Г
	7.Дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх ажлыг дэмжиж ажиллах;	Дэмжиж ажилласан байна.	Х, Ш
	8.Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн бүтэц, тогтолцоог боловсронгуй болгох, тамирчдын амжилтыг дээшлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;	Орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Х
	9.Засгийн газрын шийдвэрийн дагуу улс орон даяар зохион байгуулагддаг спорт наадмуудыг дүүргийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, тайлан мэдээг нэгтгэх, үр дүнг үнэлэх;	Тайлан мэдээг нэгтгэж, үр дүнг үнэлсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1. Спортын үйл ажиллагаа, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг тооцох, тайлагнах ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулна.	Хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х, Ш
	2.Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилт, бусад холбогдох бодлогын баримт бичигт спортын	Холбогдох саналуудыг тусган хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г, Х

	талаар тусгах саналыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, гүйцэтгэл, үр дүнг тооцох, тайлагнах;		
	3.Спортын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой норм, стандартуудын хэрэгжилтэд хяналт тавих, сурталчлах ажлыг зохион байгуулах;	Норм стандартуудын хэрэгжилт, хяналт сайжирсан байна.	Г, Х
	4.Спортыг хөгжүүлэх талаар хэрэгжүүлж байгаа бодлого, чиглэл, хөтөлбөр, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, гарын авлага зөвлөмж мэдээллээр хангах;	Олон нийтэд сурталчилж, гарын авлага зөвлөмжөөр хангасан байна.	Г
	5.Байгууллагын шилэн данс болон ил тод байдлыг хангах, хөрөнгө санхүүг зөв зохистой зарцуулах, үр дүнтэй ажиллах;	Хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байна.	Х, Ш
	6.Дүүргийн биеийн тамир, спортын хороодод спортыг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж байгаа үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангах;	Мэргэжлийн удирдлагаар хангасан байна.	Г
	7.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх таатай орчин нөхцөл бүрдүүлэх асуудлаар улсын болон нийслэлийн стандарт, дүрэм, журам, төсөл хөтөлбөр, бодлогын баримт бичиг боловсруулахад оролцох, нийслэл дүүргийн биеийн тамир, спортын байгууллага, мэргэжилтэн, багш дасгалжуулагчдын саналыг тусгуулах ажлыг зохион байгуулах;	Бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцсон байна.	Г
	8.Спортыг хөгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, болзол боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Журам зааврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.Хэлтсийн болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж,	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд	Г, Х

4 дүгээр зорилтын хүрээнд	хэрэгжилтийг хангах хянах, тайлагнах, дүгнүүлэх;	хангагдсан байна.	
	2.Хэлтсийн албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;	Байгууллагын болон мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г, Х
	3.Байгууллагад хамаарах бодлогын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх хуваарь, график гаргаж, мөрдлөг болгож ажиллах. /Тогтоол шийдвэрийн тайлагналт, хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын графикт нэгтгүүлж гаргах/;	Бодлогын баримт бичгийн шийдвэрлэлтэд хяналт шинжилгээ, хийсэн байна.	Г
	4.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх;	Дүрэм журмын хэрэгжилт хангагдсан байна.	Г
	5.Хэлтсийн ажлын байруудад шаардлагатай баримт бичгийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулж холбогдох баримт материалыг цэгцлэн архивын нэгж болгох;	Стандартыг мөрдөж ажилласан байна.	Г
	6.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж, сургаж чадавхжуулах ажлыг зохион байгуулах;	Сургалтын болон нийгмийн баталгаа хангах хөтөлбөр хэрэгжсэн байна.	Г
	7.Ээлжийн амралт болон урт хугацаанд эзгүй байх тохиолдолд орлон ажиллах албан тушаалтанд ажил үүргээ албажуулан хүлээлгэж өгөх.	Хүлээлгэж өгсөн ажил албажсан байна.	Г
	8.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г
<b>III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>			

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	-Багш, биеийн тамирын боловсрол /011410/; -Спорт /1014/; -Биеийн тамир, спортын менежер.	
Мэргэшил	-	
Туршлага	Төрийн албанд 8-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Хэлтсийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах;</li> <li>- Албан хаагчдын ажил үүргийг оновчтой, тэнцвэртэй хуваарилах, чиглүүлэх, удирдах;</li> <li>- Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, зохих заавар, чиглэл өгөх;</li> <li>- Байгууллагын үйл ажиллагаанд гарч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох, авах арга хэмжээний саналыг боловсруулах;</li> <li>- Албан хаагчдын санал, бодлыг сонсох, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих;</li> <li>- Саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>-Бусад.</li> </ul>
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Спортын хөгжлийн асуудлаарх судалгааны дүн, мэдээлэлд үндэслэн зөвлөмж, санал боловсруулах;</li> <li>- Мэдээ, мэдээллийн дутуу, алдаатай, нийтлэг бус байдлыг илрүүлэх;</li> <li>- Шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх;</li> <li>- Судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>-Бусад.</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж түүний эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох;</li> <li>- Асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- Асуудлыг шийдвэрлэхдээ түүний эерэг, сөрөг үр дагаврыг тооцох;</li> <li>- Гаргасан шийдвэрийнхээ үр дагавар, эрсдэлийг хариуцах;</li> <li>-Бусад.</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- Ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанар, бусдыг дэмжих, чиглүүлэх зэргээр үлгэрлэх;</li> <li>-Шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх;</li> <li>-Итгэлцлийг бий болгох, албан хаагчдад адил тэгш хандах, зөв шударгаар дүгнэх;</li> <li>-Шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>-Зарчимч, ажил хэрэгч чанараар хамт олныг үлгэрлэн ажиллах;</li> <li>-Хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтаар хамт олныг үлгэрлэн ажиллах;</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-Биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр мэргэшсэн байх;</li> <li>-Төрийн албан хэрэг хөтлөлт, баримт бичиг боловсруулах, монгол хэл, найруулга зүйн чадвартай</li> </ul>

	байх; -Англи хэл эсхүл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах, мэдээллийн эх сурвалжийг ашиглах; -Багаар ажиллах, багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, бусдад таниулах, нээлттэй харилцааг бий болгох; -Компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэд технологи ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх;
--	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ**

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:  
Биеийн тамир, спортын хорооны дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдах албан тушаалын нэр, тоо: Мэргэжилтэн-3 - Спортын тэмцээн наадам, спортын холбоодын асуудал хариуцсан мэргэжилтэн - Өсвөрийн шигшээ баг, хүүхдийн спортын асуудал хариуцсан мэргэжилтэн - Спортын сургалт дасгалжуулалтын бодлогын хэрэгжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Бусад харилцах субъект - Байгууллагын захиргаа удирдлагын албан тушаалтан болон Биеийн тамирын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд; - Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан; - Иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын холбогдох албан тушаалтан; - Спортын холбоод, Биеийн тамирын багш, дасгалжуулагч нар.
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Тогтоол, шийдвэрийн биелэлт, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн  .....(Ө.Дариймаа)  2024 оны 03 дугаар сарын 01-ны өдөр	Байгууллагын нэр: .....  <b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ</b>  Шийдвэрийн нэр .....  Дугаар: .....

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

**БАГАНУУР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО**

Шийдвэрийн огноо..... 2024.03.01

Дугаар ..... А/18  
(тамга/ тэмдэг)

**БАГАНУУР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА** ..... (Г.СҮХБААТАР)



2024 оны 03 дугаар сарын 01-ны өдөр